

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2026.04.24

Дугаар 01

Шарын гол сум

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 14 цагт Дархан-Уул аймгийн Шарын гол сум, Санжинт 3-р багт байрлах компанийн өөрийн байрны 2 давхарын хурлын танхимд хуралдав.

Хурлын эхэнд оролцогчдын ирцийг Тооллогын комисс нэгтгэн гаргаж, “Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай” Тооллогын комиссын 01 дүгээр тогтоолыг комиссын дарга Э.Тодбаяр танилцууллаа.

Хуралд нийт 12,423,825 ширхэг саналын эрх бүхий хувьцааг төлөөлсөн 8 хувьцаа эзэмшигч оролцсоноос 7 нь саналын хуудсаар, 1 нь биечлэн оролцож, нийт саналын эрхийн 82.49 хувь хуралд оролцсон байна. Иймд Компанийн тухай хуулийн 69.1 дэх заалт болон компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах журмын 4.7 дахь заалтын шаардлагыг хангагасан тул хурлыг хүчин төгөлдөрт тооцсон болно.

Хурлын дарга Б.Мэндсайхан хурлыг нээж, оролцогчдод талархал илэрхийлэн хэлэлцэх асуудлуудыг танилцуулав. Тус хурлаар дараах хоёр асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах;
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны цалин урамшуулал, зардлын төсвийг батлах.

Хурлын хүрээнд: Гүйцэтгэх захирал Б.Мэндсайхан 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулсан бол Ерөнхий нягтлан бодогч Л.Эрдэнэжаргал санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлтийг, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Өэлүн ТУЗ-ийн үйл ажиллагаа, засаглал болон төсвийн тайланг тус тус танилцууллаа.

Хэлэлцсэн асуудлууд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай:

Дээрх тайлангуудыг дэлгэрэнгүй танилцуулсны дараа асуулт, тодруулга авахад оролцогчдоос асуулт гараагүй болно.

2. Компанийн ТУЗ-ийн 2026 оны цалин урамшуулал, зардлын төсвийг батлах тухай:

Тогтоолын төслийг танилцуулсны дараа мөн асуулт, тодруулга гараагүй болно.

Хэлэлцэх асуудлууд хэлэлцэж дууссаны дараа хувьцаа эзэмшигчид санал өгч, санал тоолох хугацаанд хурал 10 минут завсарлав. Завсарлагын дараа Тооллогын комисс саналын дүнг нэгтгэн танилцуулж, комиссын 02, 03 дугаар тогтоолыг уншиж сонгов. Үүнд:

д/д	Хэлэлцсэн асуудал	Санал			
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Хувь
1	Компанийн жилийн үйл ажиллагааны болон Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах	10,248,413			100%
2	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах	10,248,413			100%

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хэлэлцсэн асуудалтай холбогдуулан гарах тогтоолуудын төслийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Г.Өэлүн уншиж сонгов. Үүнд:

1. “Компанийн жилийн үйл ажиллагааны болон Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах”
2. “Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах”

Хурлаас гарах тогтоолын төслүүдийн талаар асууж тодруулах зүйл байгаа эсэхийг асууж, Хурлын үйл ажиллагааг хаав.

Хурал 15:00 цагт дууссан болно.

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Г.Өэлүн

Г.ӨЭЛҮН

Танилцсан:

ДАРГА



Б.МЭНДСАЙХАН